

Боловсрол, соёл, урлагийн газрын 7 хоногт  
хийсэн ажлын мэдээлэл  
/ II/26 – III/02 /

2018.03.01

№	7 хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	Орос хэлний улсын төрөлжсөн олимпиадын 3-ын даваа Улаанбаатар хотод 2 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, манай аймгаас нэг орос хэлний багш, 9 дүгээр ангийн хоёр сурагч, 12 дугаар ангийн 2 сурагч амжилттай оролцлоо. Дарын БДС-ийн 9 дүгээр ангийн сурагч Х.Еркебулан тусгай байранд орсон.		
2	Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт багш, сурагчдаас авсан Засаг даргын нэрэмжит түвшин тогтоох шалгалтын дүнг танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгууллаа.		
3	Манай аймагт 2 дугаар сарын 27-нд Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс “Бага насны хүүхдийн хамгаалал, багаараа ажиллах арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулж, нийт хүүхдийн цэцэрлэгийн 29 арга зүйч хамрагдсан.		
4	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчдийн дунд “СӨБ-ын орчин дахь хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтыг ДЗОУБ-ын тэтгэлэгээр хамтран зохион байгуулж, 29 цэцэрлэгийн эрхлэгч хамрагдсан.		
5	Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааг сайжруулан эрчимжүүлэх тусгай төлөвлөгөө гаргаж, цэцэрлэгүүдэд хүргүүлэн ажиллаж байна.		
6	Багш нарын заах арга барилыг сайжруулах, туршлага судлах зорилгоор уламжлал болон зохион байгуулж буй “Сайн хичээл -үйл ажиллагаа” бүсийн зөвлөгөөний	Зөвлөгөөнийг 3 дугаар сарын 5-наас 7-ны хооронд 4 бүсэд зохион байгуулах	

	удирдамжийг боловсруулан, сургуулиудад хүргүүлсэн.		
7	Хөгжмийн 2 багш, бага ангийн нэг багшийн судалгаат хичээлийг зохион байгуулсан.		
8	Японы хүүхдийн ивээх сангийн “Зудад өртсөн малчдын хүүхдийн боловсролыг дэмжих” төсөл дуусаж байгаатай холбогдуулан төслийн мэргэжилтэн ба БСУГ-ын физикийн судлагдахуун хариуцсан мэргэжилтэн нар Сагсай сумын ЕБ-ын БДС, Даян багийн бага сургуульд ажилласан.		